

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.10.09 № 03 / 8334
танай _____-ны № _____-т

**Тендер шалгаруулалтыг
түдгэлзүүлэх тухай**

Танай байгууллагаас зарласан ТБ/20240102071 дугаартай “Камер нийлүүлэх /Суурилуулах” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Арвиссистемс” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.1-д заасны дагуу гомдол гаргасан байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.6 дахь хэсгийг үндэслэн захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлж байна.

Иймд гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгийг 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн дотор ирүүлнэ үү. Үүнд:

- 1.Батлагдсан төсөвт өртгийн шийдвэрийн хуулбар;
- 2.Үнэлгээний хороо байгуулсан шийдвэр;
- 3.Батлагдсан тендер шалгаруулалтын баримт бичиг;
- 4.Оролцогчдын ирүүлсэн тендер /Тендер нээх нууц үг/;
- 5.Тендерийн нээлтийн тэмдэглэл;
- 6.Үнэлгээний хорооны зөвлөмж, хурлын тэмдэглэл;
- 7.Оролцогч болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг;
- 8.Гэрээ байгуулах эрх олгох, шалгараагүй болон татгалзсан тухай шийдвэр;
- 9.Захиалагч гомдол хянан шийдвэрлэсэн бол холбогдох шийдвэр;
- 10.Холбогдох бусад баримт бичиг.

Түүнчлэн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.9 дэх хэсэгт заасны дагуу оролцогч нарт энэхүү шийдвэрийг мэдэгдэх, журмын 5.2-т заасны дагуу гомдол гаргагчийн тендерийн баталгааг чөлөөлөхгүй байхыг анхаарна уу.

Гомдлыг хянан шийдвэрлэх хугацаанд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасан хугацаа зогсох болно.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Ж.ГАНБАТ

9766015611